



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/545

Булган сум

**Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын
бэлтгэлийг хангах нэгдсэн төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 28 дугаар “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн мал аж ахуйн 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), сумын Засаг нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн дүн мэдээг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын удирдлагын багт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010795

АЙМГИЙН Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн АХУЙН Засаг захиралжийн хавсралт



БУЛГАН АЙМГИЙН МАЛ АЖ АХУЙН 2024-2025 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах хүн	Хамтран ажиллах байгууллага /хүн/	Хяналт тавих хүн	Санхүүжилтийн эх үүсвэр
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар						
1.1.	Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах 2024-2025 оны аймгийн нэгдсэн төлөвлөгөөг батлуулж, сумдад хүргэх	08 дугаар сарын 10	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
1.2.	Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах сумын комисс томилж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	08 дугаар сарын 10 10 дугаар сарын 01	Сумын Засаг дарга	Байгууллага, аж ахуйн нэгжийн дарга	ХХААГ-ын дарга	Улс, орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, малчдын өөрийн хөрөнгө
1.3.	Сумдын мал аж ахуйн 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан байдлыг шалгах, эрчимжүүлэх үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	08 дугаар сарын 15 10 дугаар сарын 15	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
1.4.	Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	08 дугаар сарын 05 10 дугаар сарын 05	АЗДТГ-ын ХМОНХА-ны дарга, Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга, СМ ТВ-ийн захирал	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
1.5.	Мал аж ахуйн эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлж, хашаа, саравчаа дулаалах, өвс, тэжээл, хужир, шүү, өтөг бууц нөөцлөх сарын аян зохион байгуулах	08 дугаар сарын 06 09 дүгээр сарын 06	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв

1.6.	Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бэлтгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, дүн шинжилгээ хийх	09 дүгээр сарын 10	ХХААГ-ын дарга, "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК, Сумын Засаг дарга	Ажлын хэсэг	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
1.7.	Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, орлого бүрдүүлэлтийг ил тод болгох, орлогын эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлэн зарцуулах, хяналт тавих	Жилдээ	Сумын Засаг дарга	Татварын хэлтэс, ХХААГ-ын дарга, МЭГ-ын дарга	Аймгийн Засаг даргын орлогч, АЗДТГ-ын ХБТХОХ, НБХ-ийн дарга нар	-
Хоёр. Мал сүргийг эрсдэлээс хамгаалахад иргэний нийгмийн байгууллага, төсөл хөтөлбөрийн оролцоо, хамтын ажиллагааг чиглүүлэх талаар						
2.1.	Могод, Хишиг-Өндөр, Орхон, Дашинчилэн сумдад байгуулагдсан бэлчээр ашиглагчдын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрчимжүүлэх	08 дугаар сарын 20 11 дүгээр сарын 01	Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, Сумын Засаг дарга нар	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
2.2.	Рашаант, Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Сайхан, Хангал сумдын нийт 30.0 мянган га бэлчээрийн талбайд хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулах	10 дугаар сарын 15 11 дүгээр сарын 15	Холбогдох сумдын Засаг даргын орлогч	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
Гурав. Хадлан, тэжээл бэлтгэлийн ажлыг зохион байгуулах талаар						
3.1.	Бэлчээрийн ургамлын ургацын байдалд дүгнэлт хийж, хадлан бэлтгэх сумын төлөвлөгөө, зураглал гаргах	07 дугаар сарын 15 09 дүгээр сарын 01	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
3.2.	Аймаг, сумын нөөц болон малчдын хэрэгцээнд бэлтгэх хадлангийн талбайг хамгаалалтад авч, мал оруулахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	06 дугаар сарын 01 10 дугаар сарын 01	Сумын Засаг дарга	ГХБХБГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
3.3.	Аймгийн хэмжээнд 111.2 мянган тн-оос доошгүй байгалийн хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулах	08 дугаар сарын 01 10 дугаар сарын 25	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Малчдын хөрөнгөөр

3.4.	Аймгийн нөөцөд 300 тн өвс, 60 тн тэжээл, сумын нөөцөд 1600 тн өвс, 480 тн тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулах	08 дугаар сарын 05 10 дугаар сарын 10	“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК, Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
3.5.	Талхлалт, давталтад орсон бэлчээрийн 59.7 мянган га талбайг малын хөлөөс чөлөөлж, 179.4 мянган га талбайг сэлгэж ашиглах, нөхөн сэргээх, хашиж хамгаалах ажлыг зохион байгуулах	06 дугаар сарын 15 10 дугаар сарын 01	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв
3.6.	Хил залгаа аймаг, сум хооронд уулзалт зохион байгуулж, цаг хүндэрсэн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	08 дугаар сарын 20 11 дүгээр сарын 01	Сумын Засаг дарга нар	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
3.7.	Аймаг дундын “Чилэн” отрын бүс нутгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	08 дугаар сарын 20 11 дүгээр сарын 01	Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв
3.8.	Бэлчээрийн доройтолд мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн өөр аймаг, сумаас отрын мал хүлээн авахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, урьдчилан мэдээлж, хяналт тавьж ажиллах	08 дугаар сарын 01 10 дугаар сарын 01	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
Дөрөв. Худаг, уст цэгийн эзэмшилт, ашиглалт, хашаа хорооны хангамжийг сайжруулах						
4.1.	Шинээр барьсан өвөлжөө, хаваржааны хашаа саравчинд өтөг, бууц нөөцлөх, худаг уст цэгийг дулаалах, төл хүлээн авах байр бэлтгэх ажлыг зохион байгуулах	08 дугаар сарын 20 11 дүгээр сарын 01	Малчид, багийн Засаг дарга	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	Малчдын хөрөнгө
4.2.	Инженерийн хийцтэй 16 худаг шинээр гаргах ажлыг зохион байгуулж, хүлээн авах, эвдэрсэн худгийг засварлах, ашиглалтад хяналт тавих	08 дугаар сарын 20 10 дугаар сарын 25	Сум, багийн Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв, малчдын хөрөнгө

Тав. Мал үржлийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

5.1.	Малчдад малын чанар, үржлийн ажил үйлчилгээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах	08 дугаар сарын 20 12 дугаар сарын 05	ХХААГ-ын дарга	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
5.2.	Малын генетик нөөцийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Мал хамгаалах талаар малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдийн хүлээх үүргийн хэрэгжилтийг хангуулах	08 дугаар сарын 20 12 дугаар сарын 01	Сумын Засаг дарга, малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээд	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгө
5.3.	Хээлтүүлэгчийн үзлэг ангилалт, заазлалтыг чанартай гүйцэтгүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх	08 дугаар сарын 20 10 дугаар сарын 01	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улсын төсөв, малчдын хөрөнгө
5.4.	Сум бүр хээлтүүлэгч малдаа үзлэг ангилалт хийж, дутагдаж байгаа хээлтүүлэгчийг нөхөж тавих, баталгаажсан үүлдэр, омгийн хээлтүүлэгчийг үржилд ашиглах	08 дугаар сарын 20 11 дүгээр сарын 20	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улсын төсөв, малчдын хөрөнгө
5.5.	Аймгийн хэмжээнд 2024 онд хээлтүүлэгт ашиглах нийт 13906 малыг 100 хувь бруцеллёзын шинжилгээнд хамруулах (Бух -3147, Хуц -7451, Ухна-4083)	08 дугаар сарын 01 10 дугаар сарын 20	Сумын Засаг дарга нар	МЭГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улсын төсөв, малчдын хөрөнгө

Зургаа. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

6.1.	Мал эмнэлгийн үйлчилгээг шуурхай, зохион байгуулах, мал сүргийг халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1.2 сая мал, амьтан хамруулах	08 дугаар сарын 20 12 дугаар сарын 20	МЭГ-ын дарга	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв
6.2.	Малын шимэгчтэх өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх "Хариуцлагатай малчин-Эрүүл мал" аяныг 2 үе шаттай зохион байгуулах	07 дугаар сарын 03 10 дугаар сарын 15	МЭГ-ын дарга	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв
6.3.	Малын гоц халдварт шүлхий, гахайн мялзан, үхрийн арьс товруутах, шинэ болон дахин сэргэж буй өвчин, зэрлэг амьтдын гоц халдварт өвчний тандалт	2,3,4-р улиралд	МЭГ-ын дарга	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв

	Шинжилгээ хийж, тогтмолжуулах	хяналтыг				
6.4.	Адууны халдварт өвчний тандалт, үхэрт сүрьеэ, лейкоз, үхрийн цээж, тархи сархиатах өвчний тандалт, зөгийн Европ, Америк үжил өвчний тандалт, малын эмийн үлдэгдлийн шинжилгээг хийх	2,3,4-р улиралд	МЭГ-ын дарга	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв
6.5.	Мал, мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо вакцинжуулалт, тарилга туулгалтын хугацааг сайтар хянах, хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	Жилдээ	МЭГ-ын дарга, Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв, малчдын хөрөнгө
6.6.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 13.5, 34.1, 34.3 дахь заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах	05 дугаар сарын 20 10 дугаар сарын 01	МЭГ-ын дарга, Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
6.7.	Отрын мал сүргийг урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд хамруулах, хяналт тавих	09 дүгээр сарын 01 11 дүгээр сарын 20	Сумын Засаг дарга	МЭГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
6.8.	Зүй бусаар болон тодорхой шалтгаанаар хорогдсон малын сэг зэмийг устгах ажлыг тухай бүр нь шуурхай зохион байгуулах, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Жилдээ	Сумын Засаг дарга, малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээд	МЭГ-ын дарга БОАЖГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
Долоо. Цас, зудын бэрхшээлийг хохирол багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах						
7.1.	Малчдад бэлчээр ашиглалт, нөхөн сэргээлт, цаг агаарын болзошгүй эрсдэлийг хамтын хүчээр даван туулах, малаа эдийн засгийн эргэлтэд оруулах талаар зөвлөмж, чиглэл өгөх	08 дугаар сарын 01 12 дугаар сарын 01	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
7.2.	Ган, зудын үед шаардагдах унаа, бензин, шатахуун, эм бэлдмэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах	08 дугаар сарын 01 10 дугаар сарын 10	ОБГ-ын дарга, Сумын Засаг дарга	ЭМГ-ын дарга, ХХААГ-ын дарга	Аймгийн Засаг даргын орлогч	Орон нутгийн төсөв

7.3.	Цагийн байдал хүндэрсэн үед авах арга хэмжээг тодорхой болгож, малчид хоол хүнс, дулаан хувцас, ахуйн хэрэглээний бараа, түлш бэлтгэн нөөцлөх арга хэмжээг зохион байгуулах	08 дугаар сарын 01 11 дүгээр сарын 01	Сумын Засаг дарга	ОБГ-ын дарга, ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв, малчдын хөрөнгө
7.4.	Цасанд хаагдсан зам давааны цас арилгах, зам гаргах хөдөлгөөнт орон тооны түр отрядыг томилж, тодотгох	Тухайн үед	Сумын Засаг дарга	ОБГ-ын дарга, Булган АЗЗА ТӨХК захирал	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
7.5.	Сумын онцгой комиссын бэлэн байдлыг хангах	Жилдээ	Сумын Засаг дарга	ОБГ-ын дарга	Аймгийн Засаг даргын орлогч	-
7.6.	Цаг агаарын урьдчилсан төлөвийн таарцыг сайжруулахад анхаарч, мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж, шуурхай мэдээлж ажиллах	Жилдээ	УЦУОШТ-ийн дарга	ОБГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
7.7.	Малчдад цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ, сэрэмжлүүлгийг тухай бүрт нь шуурхай дамжуулан хүргэх	Жилдээ	УЦУОШТ-ийн дарга	ОБГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
7.8.	Үүлэнд зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх арга хэмжээг тухай бүр мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх	Тухайн үед	УЦУОШТ-ийн дарга	ОБГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Улс, орон нутгийн төсөв
7.9.	Малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, хувийн бэлтгэлийг хангуулах	08 дугаар сарын 01 11 дүгээр сарын 01	Сумын Засаг дарга	ЭМГ-ын дарга	НБХ-ийн дарга	
7.10.	Шаардлагатай хүн, малын эмийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	08 дугаар сарын 01 11 дүгээр сарын 01	Сумын Засаг дарга нар	ЭМГ-ын дарга, МЭГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ, НБХ-ийн дарга нар	Орон нутгийн төсөв
7.11.	Ган, зуд зэрэг байгалийн гамшгийн үед аймгийн Онцгой комиссын сэрэмжлүүлэг гаргаж сумдад хүргүүлэх	Тухайн үед	ОБГ-ын дарга, УЦУОШТ-ийн дарга	ХБТХОХ-ийн дарга	Аймгийн Засаг даргын орлогч	-
7.12.	Аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг шалгаж, хүлээж авах ажлыг зохион байгуулах	10 дугаар сарын 01	"Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК, Сумын Засаг дарга	Ажлын хэсэг	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-

7.13.	Мал ядарч, доройтсон үед тэжээх нэмэгдэл тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг малчдаар гүйцэтгүүлэх	08 дугаар сарын 01 10 дугаар сарын 01	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
7.14.	Сумын зудын гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	05 дугаар сарын 01 12 дугаар сарын 01	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн	ОБГ-ын дарга, ХХААГ-ын дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	-
7.15.	Мал ядарч, доройтсон үед тэнхрүүлэх, нөхөн сэргээх арга зүйн зөвлөмж зөвлөгөөг малчдад өгөх, эмийн ургамлаар шингэн нөхөх уумал, бэмбий, тосон түрхлэг хийх арга зүйгээр хангах	08 дугаар сарын 20 12 дугаар сарын 05	ХХААГ-ын дарга МЭГ-ын дарга,	Сумын Засаг дарга	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга	Орон нутгийн төсөв
Найм. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг шалгаж хүлээн авах, төлөвлөгөөний биелэлтийн бүрэн хангуулах						
8.1.	Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалтыг баг, суурь, малчин өрх бүрээс шалган хүлээж авах	09 дүгээр сарын 15 10 дугаар сарын 15	Сумын комисс	Сумын Засаг дарга	ХХААГ-ын дарга	-
8.2.	Сумдын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалтыг аймгийн ажлын хэсэг 3 үе шаттай хүлээн авна. Үүнд: 1-р шат. Сумдын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлын дүнг хүлээн авч нэгтгэх	10 дугаар сарын 15	Ажлын хэсэг	АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга, ХХААГ-ын дарга	Аймгийн Засаг даргын орлогч	-
	2-р шат. Өвөлжилтийн бэлтгэлийн зохион байгуулах арга хэмжээний биелэлтийг газар дээр нь үзэж, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дутуу ажлыг гүйцээх чиглэл өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлох	10 дугаар сарын 25 11 дүгээр сарын 10				
	3-р үе шат. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах	11 дүгээр сарын 15				

---оОо---